



МОНГОЛ УЛС  
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2024 оны 02 сарын 22 өдөр

Дугаар А/19

Мөрөн сум

Төсөвт зохицуулалт хийх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.5, 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8, 42 дугаар зүйлийн 42.2.1а, 65 дугаар зүйлийн 65.1.7, Засгийн газрын 2024 оны 02 дугаар сарын 14-ний өдрийн 62 дугаар тогтоол, Сангийн сайдын 2018 оны 134 дүгээр тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Улс болон аймгийн хэмжээнд өвөлжилт, хаваржилтын нөхцөл байдал эрс хүндэрч өндөржүүлсэн бэлэн байдал зарласан, хэд хэдэн сум зудын эрсдэлийн “их”, “дунд” түвшинд хүрсэн, өвс тэжээлийн нөөц дуусч нэмж бүрдүүлэх шаардлагатай болсон, цасанд хаагдсан зам давааг нээхэд нэмэлт зардал хэрэгтэй болсон, эдгээр асуудлаас үүдэлтэй өглөг үүссэнийг барагдуулах шаардлагатай байгаа зэргийг харгалзан аймаг, сумдын “Орон нутгийн нөөц” хөрөнгө, “Гамшгийг эрсдэлийг бууруулах” зардлыг аймаг, сумдын 2023 оны давсан орлого, дансны үлдэгдлээс нэмэгдүүлэн зохицуулах жагсаалтыг хавсралтаар баталсугай.

2. Төсвийн зохицуулалтыг хийж, зарлагын сарын хуваарьт өөрчлөлтийг тусгаж батлуулан, мөрдөж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Г.Базар)-д зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (М.Хуягбаатар)-д даалгасугай.

ДАРГА



П.ЛХАГВАЖАВ



Аймгийн Засаг даргын 2024 оны  
02 дугаар сарын 27-ны өдрийн  
А/79 дүгээр захирамжийн хавсралт

Аймаг, сумдын 2023 оны давсан орлого, дансны үлдэгдлээс "Орон нутгийн нөөц",  
"Гамшгийн эрсдэл бууруулах" зардлын нэмэгдүүлэх жагсаалт  
/мянган төгрөгөөр/

№	Аймаг, сум	Орон нутгийн нөөц хөрөнгийг нэмэгдүүлэх	Гамшгийн эрсдлийг бууруулах зардлыг нэмэгдүүлэх	Санхүүжүүлэх эх үүсвэр /тайлбар/
1	Алаг-Эрдэнэ	29,200.0	13,000.0	Сумын 2023 оны дансны үлдэгдлээс
2	Баянзүрх	16,609.2		Сумын давсан орлого 5.8 сая, дансны үлдэгдэл 3.6 сая, Малын тоо толгойн татварын давалт 7.2 сая
3	Галт	60,000.0		Сумын 2023 оны давсан орлого
4	Жаргалант	74,353.4		Сумын 2023 оны дансны үлдэгдлээс
5	Их-Уул	40,000.0		Сумын 2023 оны дансны үлдэгдлээс
6	Рашаант	46,000.0		Сумын 2023 оны давсан орлого
7	Ренчинлхүмбэ	5,000.0		Сумын 2023 оны дансны үлдэгдлээс
8	Төмөрбулаг	50,000.0		Сумын 2023 оны дансны үлдэгдлээс
9	Улаан-Уул	22,000.0		Сумын 2023 оны давсан орлогоос 15.5 сая, дансны үлдэгдлээс 6.5 сая
10	Цагаан-Уул	30,000.0		Сумын 2023 оны дансны үлдэгдлээс
11	Цэцэрлэг	50,000.0		Сумын 2023 оны дансны үлдэгдлээс
12	Шинэ-Идэр	77,365.0		Сумын 2023 оны давсан орлого, дансны үлдэгдлээс
13	Хатгал	10,000.0		Сумын 2023 оны давсан орлогоос
14	Аймаг		90,000.0	Аймгийн 2023 оны дансны үлдэгдлээс
	<b>ДҮН</b>	<b>510,527.6</b>	<b>103,000.0</b>	